



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.04.18 № 2/265  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Заг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох Баянхонгор аймгийн Заг сумын Ардчилсан намын хорооноос ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Баянхонгор аймгийн Заг сумын Ардчилсан намын хорооны Заг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн

005920587

37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага, Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлогод тус тус нийцсэн байна.

Заг сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр /4 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Баянхонгор аймгийн Заг сумын Сонгуулийн хороонд  
Хавсралт 4... хуудастай.

АУДИТЫН  
МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ХЯНАСАН:  
АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА

БОЛОВСРУУЛСАН:  
АУДИТОР

Н.БАТЧИМЭГ





АРДЧИЛСАН НАМ  
Заг сумын  
АН-ын хорооны тэргүүлэгчдийн  
хурлаар хэлэлцэж батлав.  
2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр

8400916 ХНТ0972

## БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАГ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН 2020-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ НӨХӨН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**Хөтөлбөрийн уриа: Хүн бүрд орлого, өрх бүрд өсөлт**

**Нэг. Хүртээмжтэй эдийн засаг, өсөлтийг хангах бодлого**

1.1. Сумын ДНБ-ний үйлдвэрлэлийг жил бүр өсгөж, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээг “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”-ын баримт бичигт заасан хэмжээнд хүргэх.

1.2. Сумандаа байгаа ахуйн үйлчилгээ, гар урлал, гутал, оёдлын цех, үйлдвэрүүдийн үйл ажиллагааг бүх талаар дэмжинэ.

1.3. Загт үйлдвэрлэв” сүлжээ дэлгүүрийг сумандаа байгуулж орон нутгийн жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалт, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

1.4. “Алсын хараа 2050” заалтад хамааруулж мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалтын болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.

1.5. Төмс хүнсний ногоогоор нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, энэ үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлэх

**Хоёр. Хувь хүний хөгжил, эрх чөлөө**

**2.1. Боловсрол**

2.1.1. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, хүүхдэд ээлтэй сургалтын орчныг бүрдүүлнэ.

2.1.2. Багшлах боловсон хүчинд тавих шаардлагыг өндөрсгөж, тэдний мэргэжлийн болон багшлах ур чадварыг дээшлүүлнэ.

2.1.3. Сургууль, эцэг эх, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, боловсролын салбарын үйл ажиллагааг дэмжсэн хөрөнгө оруулалт хийсэн иргэд ААН, байгууллагуудыг дэмжинэ.

2.1.4. Сургууль цэцэрлэг, соёлын төвийг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилгын засвараар үе шаттай хангаж, сургууль, цэцэрлэгийн удирдлагын чадавхыг сайжруулна.

2.1.5. Анги дэвших төгсөх болон хөндлөнгийн шалгалтын үнэлгээгээр хариуцсан ангиа 60-аас дээш хувийн гүйцэтгэлтэй шалгуулсан бага ангийн багш нарыг урамшуулдаг тогтолцоог бий болгоно.

2.1.6. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтад малчдын хүүхдийг хамруулна.

2.1.7. Багш солилцох хөтөлбөрийг хэрэгжүүлэх

0000001

## 2.2.Эрүүл мэнд

2.2.1. Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг байнга дээшлүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулан, шаардлагатай хүмүүсийг дараагийн шатны үзлэг, оношилгоо, эмчилгээнд хамруулж хэвшинэ.

2.2.2. Уламжлалт анагаах ухааны чиглэлээр эрэлт хэрэгцээнд нийцсэн өрсөлдөх чадвар сайтай хувийн хэвшлийн эмнэлгийг хөгжүүлэх

2.2.3. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын мэргэжил, боловсролыг тасралтгүй дээшлүүлэх, сургалтад хамруулах, ур чадварын нэмэгдэл олгох, салбарын удирдлагын менежментийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2.4. Эрүүл мэндийн байгууллагыг нэн шаардлагатай орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр эн тэргүүнд хангана.

2.2.5. Эх, нялхсын эндэгдлийг аймгийн /2016-2025 он/ хөгжлийн бодлогын баримт бичигт заасан түвшинд хүртэл бууруулна..

2.2.6. Эмийн сангийн менежментийг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн хэлбэрээр хөгжүүлж, эм, эмнэлгийн хэрэгслийн чанартай ханган нийлүүлэлт, үнийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ.

## 2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн хамгаалал

2.3.1. Үр ашигтай жижиг дунд үйлдвэрлэлийг орон нутгийн бодлогоор дэмжиж, төв суурины өрх бүрээс 1 хүнийг тогтвортой ажлын байртай байлгах бодлого хэрэгжүүлнэ.

2.3.2. Өрхийн үйлдвэрлэлийн өсөлтийг бүх талаар дэмжиж, бага оврын дэвшилтэт тоног төхөөрөмжийн мэдээллийг иргэдэд хүргэх, зуучлах, тоног төхөөрөмжийг түрээслэх, лизингийн зээлээр олгох үйлчилгээг хөгжүүлнэ.

2.3.3. Шинээр ажлын байр бий болгож нутгийн иргэдийг тогтвортой ажлын байраар хангасан ААН-үүдийг жил бүр шалгаруулж, тэдний үйл ажиллагааг дэмжиж урамшуулдаг тогтолцоог бий болгоно.

2.3.4. Зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, тэдэнд чиглэсэн төрийн халамжийн бодлогыг хүртээмжтэй хүргэхийн зэрэгцээ тэдний ажил хөдөлмөр эрхлэх идэвх санаачилга, боломжийг дэмжиж, хөгжүүлнэ.

2.3.5. Залуу гэр бүлийг эхний ээлжинд ажлын байр, хөнгөлөлттэй тохилог сууцанд хамруулах, оюутан залуусыг дэмжих бодлого баримтална.

## Гурав. Хөдөө аж ахуй, Байгаль орчин

### 3.1. Мал аж ахуй

3.1.1. Мал сүргийг чанаржуулж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлж, малынхаа тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах бодлогыг баримтална.

3.1.2. Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг уламжлалт болон орчин үеийн технологиор боловсруулах жижиг дунд үйлдвэрийг байгуулан хөгжүүлнэ.

3.1.3. Сумын хонин сүрэгт Баяд үүлдрийг сайжруулагчаар ашиглаж, амьдын жин, ноосны гарцыг нэмэгдүүлнэ.

3.1.4. Сумын ямаан сүрэгт "Бөмбөгөрийн улаан", Хөвсгөлийн "Эрчмийн хар" ямааг сайжруулагчаар ашиглаж, нэгжээс авах ноолуурын гарц, чанарыг тогтвортой түвшинд байлгах, сайжруулах.

3.1.5. "Малын эрсдэлийн сан"-г байгуулан, бэлчээр хамгаалах, сэргээх, бэлчээрийн уст цэгийг нэмэгдүүлэх, цөлжилтийг бууруулах, хөв цөөрөм байгуулах, малын эрүүл мэндийг хамгаалах, үүлдэр угсааг сайжруулах арга хэмжээг тухайн сангийн хөрөнгөөр шийддэг байх орчныг бүрдүүлнэ.



Handwritten signature and red official stamp of the Ministry of Health and Social Welfare of Mongolia. The stamp contains the text '64171' and '40A006'.



3.1.6. Малын эрүүл мэндийг хамгаалахад анхаарч, малын эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллуулж, мал эрүүлжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулна.

### **3.2.Газар тариалан:**

3.2.1. Тохиромжтой бүсүүдэд төмс,хүнсний ногоо, малын тэжээл, хадлан бэлтгэх ашиглах арга хэмжээ авна.

3.2.2. Төмс, хүнсний ногооны 100 тн –ын багтаамж бүхий стандарт зоорь барьж ашиглах асуудлыг төсөл хөтөлбөрөөр шийдвэрлэнэ.

3.2.3. Тохиромжтой газруудад 4 улирлын ажиллагаатай хүлэмжийн тариалалтыг хөгжүүлэх.

3.2.4. Жил бүр мал аж ахуйн салбарын өвөлжилт хаваржилтын үеийн 7 хоногт шаардлагатай хадлан тэжээлийг бэлтгэнэ.

3.2.5. Газар тариалангийн бүсэд байгаа инженерийн хийцтэй услалтын системийг засварлаж, бүрэн ашиглах

### **3.3.Тогтвортой байгаль орчин**

3.3.1. Газар зохион байгуулалтын төлөвлөлтөд тусгах замаар төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг одоогийн түвшингээс 2 дахин нэмэгдүүлнэ.

3.3.2. Хөдөөгийн эвдэрсэн газруудыг бүрэн нөхөн сэргээх ажлыг оновчтой зохион байгуулна.

3.3.3. Хог хаягдлыг ангилан ялгах ажлыг зохион байгуулж, байгальд хор хөнөөлтэй хогийг дахин боловсруулж, хог тээврийн машины ашиглалтыг бүрэн сайжруулна.

3.3.4. Гол горхи,булаг шандны эхийг хамгаалах, ойжуулах, модлог ургамлуудыг тариалах, ногоон массыг нэмэгдүүлэх.

3.3.5. Нүүдлийн МАА-н соёл иргэншилд суурилсан нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг Халиутын рашаан , түүхт Хүрэн бэлчирт хөгжүүлнэ.

## **Дөрөв. Хуулиа дээдэлдэг, иргэддээ үйлчилдэг засаглал**

### **4.1.Сайн засаглал**

4.1.1.Засаг захиргааны бүх шатанд хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэх чадвартай, авилгаас ангид байж, иргэндээ чанартай үйлчилгээ үзүүлдэг засаглалыг төлөвшүүлнэ.

4.1.2.Төрийн байгууллагуудад орон тоо гарсан нөхцөлд олон нийт, хамт олны оролцоог хангасан,мэдлэг ур чадварт суурилсан нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгодог тогтолцоог дагаж мөрдөнө.

4.1.3. Иргэдээс төрийн алба, албан тушаалтантай холбоотой авлига,хээл хахууль, ашиг сонирхлын зөрчлийн талаар гаргасан мэдээллийг хүлээн авах цахим орчныг бүрдүүлж, түүний нууцыг хадгалж, мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийж, хариуцлага тооцох зарчмыг нэвтрүүлнэ.

### **4.2.Төсөв санхүү**

4.2.1. Төсвийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтаар дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэр эрхлэгчдийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.

4.2.2.Төсвийн зардлыг ач холбогдлоор нь эрэмбэлэх зарчимд шилжиж, алдагдлыг багасган хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж, сумын төсвийн чадавхыг нэмэгдүүлнэ.

4.2.3. Төсвийн ил тод байдлыг хангах шаардлагын дагуу Шилэн дансанд мэдээллийг тогтмол байршуулж, ил тод хяналттай төсвийг бий болгоно.


### **4.3. Сум, багийн хөгжил.**

4.3.1. Сумандаа дэд бүтцийг нь бүрэн шийдсэн 30-50 айлын хувийн хаус хороолол, орон сууцыг хувийн хэвшилтэй хамтарч ашиглалтад оруулна.

4.3.2. Сумын төвийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд “Шинэ гудамж”, “Ногоон хороолол” төсөл хэрэгжүүлж, өрх бүр хашаандаа мод,хүнсний ногоо тариалж, орчноо ногооруулна. Төвийн бүсэд байгаа орон сууц, гэр хорооллын халаалтын асуудлыг шийдвэрлэнэ

4.3.3. Баян-Улаан, Баянбулаг багуудын байрыг шинэчлэх .



 0000003

007423

4.3.4. Сумын тохижилтыг сайжруулж, гэрэлтүүлэг, камержуулах, ойжуулах, алжаал тайлах, амрах байр, тав тухтай орчныг бүрдүүлнэ.

4.3.5. Загийн голын гүүрний асуудлыг шийдвэрлэж, бетонон гүүр барина.

4.3.6. Шинээр баригдаж буй Соёлын төв, бага сургууль, Ахмадын өргөө, Ахмадын өдөр өнжүүлэхийн байрыг гүйцээж барина.



#### 4.4. Гэмт хэрэг зөрчлийг бууруулах

4.4.1. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгөөр үр дүнтэй зохион байгуулж, Бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 2 дахин бууруулна.

4.4.2. Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулж "Архигүй Загчууд" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

4.4.3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд эрчимжүүлж "Малын хулгайгүй сум" болохыг зорино.

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАГ СУМЫН АРДЧИЛСАН НАМ**

000000!